



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/194

Мандалговь

Эх дэлхийгээ аваръя жиргээ  
холбоотой гэрээ тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлийн 34.2 Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаарын сарын 28-ны өдрийн А/198 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн дулаарал, цаг агаарын өөрчлөлт, газрын доройтол, цөлжилт, хуурайшилтын эсрэг модны экологи, эдийн засгийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулан, экологийн боловсролыг дээшлүүлэх замаар аймгийн хэмжээнд “8 ТҮМЭН МОД” тарих ХӨДӨЛГӨӨН-ийг өрнүүлэн мод тарьж, усалж, арчлан ургуулах мэдлэг, дадлага олгох зорилгоор зохион байгуулагдаж байгаа “Дундговио ногооруулья” сургалтын төслийг “Эх дэлхийгээ аваръя жиргээ холбоо” Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.

2. Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд “Эх дэлхийгээ аваръя жиргээ холбоо” НҮТББ-д шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 9,379,000 (Есөн сая гурван зуун далан есөн мянга) төгрөгийг аймгийн 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих “Хүнсний ногоо, ногоон байгууламж эрхлэгчдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөр” ажлын батлагдсан зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-д, гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



48521190